

ЯПОНЫ ДЭЭД БОЛОВСРОЛЫН ОНЦЛОГ БА ЗАРИМ АСУУДАЛ

С.ТУУЛ

*МУИС-ийн ШУС-ийн ХУС-ийн Гадаад хэлний сургалтын
төвийн доктор (Ph.D), профессор*

Д.ОЮУНЦЭЦЭГ
МУИС, ХУС, НББСТ

Л.ЭНХЖИН
МУИС, ШУС, ХУС, ГХСТ
магистр

Товч агуулга: Япон улс 1973 он хүртэлх эдийн засгийн огцом хөгжлөөрөө дэлхийн өндөр хөгжилтэй хоёр дахь улс болсон. Үүний зэрэгцээ их дээд сургууль, оюутан сурагчдын тоо ч нэмэгдэж байлаа. Гэхдээ, 1973 оноос хойш эдийн засгийн өсөлт зогсож, тогтворжуулах бодлогод шилжсэн юм. Японы дээд боловсролын байгууллагууд дэлхий нийтийн даяарчлалын үндсэн дээр өрсөлдөөнд нэгдэн оролцож байна. Нөгөө талаар, их сургуулийн хаалттай бүсэд шахагдан орох жижиг дунд их дээд сургууль ч гарах болж, түүнээс үлдсэн бодлого ч байсаар байна. Японд боловсролын ихэнх салбарт, хөдөлмөрийн зах зээлд ч урьдын адил хүйсийн ялгаа ажиглагддаг. Ялангуяа анх удаа дээд боловсрол эзэмшигчид (Их сургууль төгсөгчид)-д эзлэх эмэгтэйчүүдийн харьцаа доогуур. Японы залуучуудын 4 хүн тутмын 3 нь амьдралынхаа явцад дээд боловсрол (Ихэвчлэн богино хугацааны болон бакалаврын сургалт) эзэмшдэг гэж болно. Японы дээд боловсролын сургуулийн оюутнууд сургалтын өндөр төлбөр төлөх шаардлагатай бөгөөд албан ёсны тусламж дэмжлэг авдаг оюутан цөөхөн. Дээд боловсролын төлбөрөө өөрөө төлдөг хувь хэмжээгээрээ Япон улс дэлхийд хамгийн өндөр нь байдаг.

Түлхүүр үгс: Магадлан итгэмжлэл, кредит систем, Японы засгийн газрын бодлого, эдийн засгийн өсөлт, ард түмний хүсэлт

Оршил

1990 оноос хойш Монгол Улсын эдийн засгийн хямрал гүнзгийрч, дээд боловсролын систем хямралд орсон. Засгийн газраас шийдвэрлэх арга хэмжээ удаа дараа авсан боловч дээд боловсролын хямрал одоо болтол бүрмөсөн шийдвэрлэгдэж чадаагүй байна.

Миний бие Болгар улсын Софи Их сургуульд 5 жилийн турш Болгар, Монголын Дээд боловсролын талаар харьцуулсан судалгаа хийж, докторын зэрэг хамгаалсан¹. Монгол, Болгар улс нь урд социалист орны тоонд багтаж байсны хувьд мөн Оросын Холбооны улсын нөлөө их байсан учраас ерөнхийдөө дээд боловсролын системд ижил төстэй зүйл олон бий.

Тиймээс дараагийн судалгааны сэдвээ дэлхийд дээд боловсролын системээрээ өндөрт тооцогддог, капиталист улсын дээд боловсролын төлөөлөгч болгон Япон орны дээд боловсролын системийг судалж, өөрийн улсын нутаг дэвсгэр, ард түмэнд тохирох, давуу талаас нь суралцаж өөрийн улсын дээд боловсролын системийг өндөр түвшин рүү дөхүүлэе гэж бодсон. Яагаад гэвэл бид гарал үүсэл, ёс заншлын хувьд адил төстэй зүйл олон байна. Мөн нутаг дэвсгэрийн хувьд ч холын Европын улсаас арай ойр дөхөм болно.


1. Японы дээд боловсролын зарим асуудал

Эхлэл

OECD-гээс дэлхийн улс орнуудын дээд боловсролын нөхцөл байдлыг жил бүр тоймлож ирсэн бөгөөд Японы 2015 оны дээд боловсролын байдлыг хараад дараах 3 зүйлийг онцолж болох юм.²

1. Японд боловсролын ихэнх салбарт, хөдөлмөрийн зах зээлд ч урьдын адил хүйсийн ялгаа ажиглагддаг. Ялангуяа анх удаа дээд боловсрол эзэмшигчид (Их сургууль төгсөгчид)-д эзлэх эмэгтэйчүүдийн харьцаа доогуур.

Хүснэгт 2. 25-34 насандаа их сургууль төгсөгчдийн хувь хэмжээ, хүйсийн ялгаа (2014 оны байдлаар)




¹ С.Туул. 1990 оноос хойшх Монгол, Болгар улсын Дээд боловсролын хөгжлийн чиг хандлагууд. Софи.

² OECD, *Education at a Glance 2015: OECD Indicator*, OECD Publishing


2. Японы залуучуудын 4 хүн тутмын 3 нь амьдралынхаа явцад дээд боловсрол (Ихэвчлэн богино хугацааны болон бакалаврын сургалт) эзэмшдэг гэж болно.

Хүснэгт 4. Анх дээд боловсрол эзэмшигчдийн харьцаа (2013 оны байдлаар)



3. Японы дээд боловсролын сургуулийн оюутнууд сургалтын өндөр төлбөр төлөх шаардлагатай бөгөөд албан ёсны тусламж дэмжлэг авдаг оюутан цөөхөн. Дээд боловсролын төлбөрөө өөрөө төлдөг хувь хэмжээгээрээ Япон улс дэлхийд хамгийн өндөр нь байдаг.

Хүснэгт 5. Боловсролын байгууллагад зарцуулдаг өөрөөсөө төлөх зардлын харьцаа (2012 оны байдлаар)



Эргэцүүлэл 1

Юуны өмнө, өнөөгийн Японы дээд боловсролын системийг ерөнхийлөн тоймловол дараах байдалтай байна.³

Эргэцүүлэл 1+

Эдийн засгийн өсөлтөд чиглэсэн сургалтыг улс санаачлан удирдаж хөгжүүлсэн бөгөөд үүнд чиглэсэн гол бодлогыг хэрэгжүүлэх дээд боловсролыг эрчүүдэд төвлөрүүлэн өрнүүлсэн байна. Эдийн засгийн өсөлтийг хэрэгжүүлэх явцад, эмэгтэйчүүд гэр орондоо түгжрэх болсон юм.

Япон дэлхийн 2-р дайнд холбоотнуудад ялагдаж, Японд орж ирсэн америкчууд антропологич Р.Бэнэдэйт-д Японы нийгэм дэх эрчүүдийн давуу байдлын тухай судалгаа хийх үүрэг өгсөн бөгөөд тэр эмэгтэй ийнхүү бичиж байжээ.

“Бүсгүйчүүд өөртөө тохирсон анхан шатны учир зүйд суралцдаггүй. Хөвгүүдээс ялгаатай нь, дунд сургууль, цэргийн боловсрол гэх мэтийн орчин үеийн туршлага, дадлага хуримтлуулж чаддаггүй. Үүнтэй төстэй зүйлд туршлагажиж ч чадахгүй. Бүсгүй хүний бүх амьдралыг ах дүүстэй нь харьцуулбал эрс ядмаг. Бүсгүй хүүхдийг ухаан суух цагт нь ямар нэгэн бодит байдлыг хүлээн зөвшөөрөхүйцээр хүмүүжүүлдэг. Тэрхүү бодит байдал гэдэг нь, хөвгүүд давуу байх, мөн хөвгүүд халамж анхаарал, бэлэг илгээмж хүртэх боловч, бүсгүй хүүхэд түүнийг тэвчих ёстой гэсэн үг. Бүсгүй хүн өөрсдийгөө хүндэлбэл зохих амьдралын ёс журмын дагуу албан ёсоор өөрийгөө хамгаалах тусгай эрхээ булаалгасан байдаг”⁴

Мөн, Нитобэ Йназо, “Бүшидо” хэмээх алдарт бүтээлийнхээ 14-р бүлэгт ийнхүү өгүүлсэн байдаг. (Монгол орчуулгаар нь үзүүлэв)

Тэдний (бүсгүйчүүдийн) хүмүүжил боловсролын дотор хамгийн чухал ажил бол гэр орныг амгалан тайван байлгах явдал бөгөөд эртний Японы эзэгтэй нарын урлагийн ажил төрөл нь дайн тулаан, энх тайван зэргээс үл шалтгаалан гол төлөв гэр бүлийнхээ төлөө байжээ. Бүсгүйчүүд ямар ч хол газар байсан гал голомтоо огт марталгүй, гэр бүлийнхээ нэр төр, нүүр царайг хадгалж явахын тулд туйлдталаа ажиллан, гэр бүлдээ бүхий л амьдралаа зориулж байв. Бүсгүйчүүд ихэд уян зөөлөн, бас зориг зүрхтэйгээр, заримдаа бас гунигтайгаар, өдөр шөнө ялгалгүй өөрсдийн жижиг “үүр гэрээ” магтан дуулсаар ирсэн билээ. Охины хувиар аавынхаа төлөө, ээжийн хувиар хүүхдийнхээ төлөө япон бүсгүйчүүд өөрсдийгөө золиосолж байжээ. Ингэж эмэгтэйчүүд бага наснаасаа л өөрийгөө

³ Higher Education Bureau, Ministry of Education, Culture, Sports, Science and Technology, *Higher Education in Japan*, http://www.mext.go.jp/english/highered/_icsFiles/afieldfile/2012/06/19/1302653_1.pdf

⁴ Ruth Benedict, *The Chrysanthemum and the Sword: Patterns of Japanese Culture*, 1946, 439-p тал(Бэнэдэйт, Удвал цэцэг ба илд)

“хоослохыг “заалгаж ирсэн юм. Тэдний насан туршдаа бие даан амьдрах биш, бусдаас хамааран аж төрж, эрчүүд эздийнхээ дотно туслагчийн хувиар оршин, шаардлагатай бол эр нөхрийнхөө хамтаар цэлмэг тэнгэрийн доор ил гарч, шаардлагагүй бол хөшигний цаагуур холдон ордог байжээ.”⁵

Өнөө үед ч энэ хэлбэр үргэлжилсээр байгаа. Боловсрол дахь хүйсийн ялгааны шалтгааны талаар Миякэ Эрико ийнхүү өгүүлжээ.

1. Дайны дараа, эдийн засгийн өндөр хөгжлийн үеийн их сургуулийн боловсролд оруулах эцэг эхчүүдийн хөрөнгө оруулалтад хөвгүүд охидоос илүү давуу эрхтэй байв.
2. Дайны дараах Японы эдийн засгийн хөгжлийн явц нь 1980-аад оны сүүлийн хагасын хөөсөрсөн эдийн засгийн оргил үе хүртэл, “Эрчүүд гадуур ажиллаж, бүсгүйчүүд хүүхдээ өсгөж, гэрийн ажил хийх” гэсэн хүйсийн ялгаатай үүрэг, ажлын хуваариар зохицуулагдаж ирсэн юм.

“Ажлын хүн” болох эрчүүдийн боловсрол хүндлэгддэг бол, “мэргэжилтэй эзэгтэй” болох бүсгүйчүүдийн боловсролыг үнэлж, хүндэлдэггүй байлаа.”⁶

Эргэцүүлэл 2

Дээд боловсролын өсөлтийн түүхэн дүр зураг.

1. XIX зуунаас хойших Засгийн газрын удирдлага доорх Японы шинэчлэл

Эдогийн үе гэгддэг дэлхийгээс тусгаарлагдсан цаг үеийг давж, нээлттэй улс болгосон Мэйжигийн засгийн газар 1872 онд боловсролын тухай хууль (“Сургуулийн тогтолцоо” гэмээр) гаргав. Үүний зорилго нь жирийн иргэдийн оюун ухааны түвшнийг дээшлүүлэх, анхан шатны сургуулийг дэлгэрүүлэх, өрнөдөөс тархсан эрдэм судлал, технологи, системийг өөрийн болгох зорилготой дээд боловсролын бэлтгэл байлаа. Тиймээс, засгийн газар Мэйжигийн эхэн үед өрнөдийн эрдэм ухаан, технологийг оруулахын тулд гадаадын мэргэжилтнүүдийг өндөр цалинтай урьж, гадаад хэлээр сургалт явуулсан байна. Мөн, үүний зэрэгцээ авьяас чадвартай олон хүмүүсийг гадаадад сургахаар илгээж байв. Олон жил шамдан суралцаад буцаж ирсэн залуучууд Япон дахь сургалтыг удирдан явуулах болсон ажээ.

⁵ Бүшидо: Япон үндэстний ёс зүйн цогц р. р.83 япон хэлнээс орчуулсан Дэлэгийн Төмөрбаатар

⁶ Миякэ Эрико, Эрэгтэй, эмэгтэйчүүдийн хамтын оролцоотой нийгэм дэх охидын ахлах сургуулийн боловсролын өнөөгийн асуудал - Doshisha эмэгтэйчүүдийн коллежийн замналын жишээн дээр, өнөөгийн нийгэм хэлэлцүүлэг No. 9, 16-38, 2013, р.20

Японы дээд боловсролын тогтолцоо нь түшмэдийн хүрээлэлд удирдагч бэлдэх их сургууль болон аж үйлдвэрийн салбар, нийгмийг хүний нөөцөөр хангах мэргэжлийн сургууль гэсэн хоёр бүтэцтэй байжээ.⁷

Хоёр удаагийн дайн (Япон-Оросын дайн 1904-1905 болон Дэлхийн I дайн 1914-1918)-ыг давсны дараа Японы капитализм хурдацтай хөгжсөн бөгөөд үүнтэй уялдан ард түмний боловсролын эрэлт хэрэгцээ нэмэгдэж, боловсролын системийг өргөтгөх, дахин эмхлэхийг шаардсан дуу хоолой ихдэв. Засгийн газар 1918 онд “Их сургуулийн хууль” гаргав. Үүний улмаас уламжлалт нэгдсэн их сургууль төдийгүй, коллеж, хувийн хэвшлийн их сургууль байгуулахыг зөвшөөрсөн юм.

Энэ үеийг хүртэл албан ёсны сургалтад элсэх хувь хэмжээ 95% хүрч өсжээ. 1920-иод он хүртэл Японы орчин үеийн сургуулийн тогтолцоо үндсэндээ бүрдсэн юм.

2. Дэлхийн II дайны дараах ардчилсан сургалт

Дэлхийн хоёрдугаар дайнд Япон улс хүнд цохилт амссан боловч, даруй сэргэж, 1950-иад оны дунд үед дайнаас өмнөх үеийн үйлдвэрлэх хүчнээс давсан байлаа. Үүнтэй уялдан, дайны дараах Японы боловсролын тогтолцоо, ардчилсан боловсролын шинэчлэлд түшиглэн 1950-иад оны эцсээр огцом өссөн юм.

1960 оноос Японы дээд боловсрол нь маш хурдацтай хөгжсөн байна. Үүнд нөлөөлсөн гол хүчин зүйл нь

1. Компанийн хөрөнгө оруулалт их болсон
2. Ард түмэн үнэн сэтгэлээсээ шударгаар хөдөлмөрлөсөн
3. Засгийн газрын мөнгөний бодлого нь гол сектор уруугаа чиглэсэн Жишээ нь: Төмрийн үйлдвэр, Хөдөө аж ахуйн сектороо хамгаалахын тулд тариачдын тарьсан будааны үнэд баталгаа өгч засгийн газар тариачдын тарьсан будааг өндөр үнээр худалдаж авсан байна.
4. Ажилчдын ажлын цалин хөлс нэмэгдсэн
5. Компанийн ажил идэвхтэй болж, ард түмэн ажлын байртай болсон

Ажлын байрны өрсөлдөөн их болж, дээд боловсролын чанар дээшилсэн. Залуус сайн ажилд орохын тулд маш сайн суралцаж, хүссэн мэргэжлээрээ ажиллах болж, “Компанийн цэрэг” гэсэн нэр алдрыг авсан байна.

⁷ Дээд боловсрол дахь “Япон загвар”-ын онцлог нь төвлөрсөн удирдлагатай боловсролын тогтолцоо байсан. Оомори Тооа “19-р зууны Америк, Европын дээд боловсролын загвар ба Японы загвар бүрэлдсэн нь – Ивамүрагийн дипломат багийн Америк, Европын дээд боловсролын тархац”

Эргэцүүлэл 3

Эдийн засгийн өсөлт дэх бүх нийтийн боловсрол: Хувийн хэвшлийн боловсролын байгууллагын өсөлт.

1980 оны үе гэхэд Япон улс эдийн засгийн өндөр хөгжлийн замд орсон юм. Өрхийн эдийн засаг тогтворжиж, хотынхны дунд давхарга өсөж, анхан шатны үйлдвэрлэлийн хүн амын тооны цөөрөлтөөс үүдсэн хөлсний хөдөлмөр нэмэгдэж, ард түмэн илүү өндөр боловсролыг эрэлхийлэх болсон юм.

Энэ нь юуны өмнө, дунд боловсрол, улмаар дээд боловсролын түвшин гэх мэтээр өргөжиж байлаа.⁸

Дээд боловсрол өргөжсөөр байлаа. Дээд сургуульд дэвшин суралцагсдын хувь 1954 онд дөнгөж 10,1% (Эрэгтэй 15,3, эмэгтэй 4,6) байжээ. 1960 онд ч онцын өөрчлөлтгүй 10,3%-тай, дээд боловсролд дэвшин суралцах нь ихээхэн шалгарсан элит шинжтэй болж байжээ. Гэхдээ, 1960-аад онд дээд боловсролын байгууллага мэдэгдэхүйц өсөж байлаа. Энэ хугацаанд, 4 жилийн их сургууль 133, дээд сургууль, коллеж 199-өөр нэмэгджээ. 1970 он гэхэд, их сургуульд дэвшин суралцагсад 23,6% (Эрэгтэй 29,9, эмэгтэй 17,7) болж гэнэт өсжээ. Дээд боловсрол бүх нийтийнх болсоор байв. Улмаар 1980 онд 37,4% (Эрэгтэй 41,3, эмэгтэй 33,7) хүртэл өссөн байна.⁹

1970 он гэхэд Япон улс эдийн засгийн их гүрэн болоод байсан бөгөөд энэ явцад ард түмэн дээд боловсролтой болохыг хүсч байлаа. Гэвч, засгийн газрын эрх мэдэл доорх дээд боловсролын байгууллагын тоо хязгаарлагдмал, ард түмний ихэнх нь дээд боловсролын хувийн сургуульд өөрийн зардлаар элсэн ордог байв. Өөрөөр хэлбэл, дээд боловсрол олон нийтийнх болсон хэдий ч, сургалтын зардлын хувь хүний төлбөр өндөр байлаа.

Жич: Дээд боловсролын сургуулийн тоо, оюутны тоо (2010.05.01-ний байдлаар)

⁸ Бага, дунд сургуулийн 9 жилийн албан ёсны боловсролын сургуулийн элсэлтийн хувь 1950 онд 99,2%-д хүрч байлаа. Шинэ системийн ахлах сургуульд дэвшин суралцагсдын хувь 1950 онд 42,5%, 1960 онд 57,7% байсан бол 1960 оноос хойш огцом өсч, 1970 онд 82,1%, 1980 онд 94,1%-д хүрсэн байна. Бага сургуульд орохын өмнө, 1-2 жил сургуулийн өмнөх сургалтад хамрах хүүхдийн тоо ч өссөн байна.

⁹ Сайто Ясүо “Японы боловсролын хөгжлийн түүх” Иномата Тошиюүки “Японы дээд боловсролд хамааралтай бодлогын өрнөлт – Дээд боловсролтой холбоотой орон нутгийн байршилтай холбоотой бодлого”

1. Сургуулийн тоо.

Хуваарилалт		Сургуулийн тоо				
		Улсын сургууль	Хот аймгийн сургууль	Хувийн сургууль (А)	Нийт тоо (Б)	Хувийн сургуулийн хувь (А/Б)
Дээд боловсролын сургууль	Их, дээд сургууль	86	95	597	778	76.7
	2-3 жилийн их сургууль		26	369	395	93.4
	Косен (Ахлах сургуулийн 3 жил +2-3 жил их сургууль)	51	4	3	58	5.2
	Нийт	137	125	969	1,231	78.1

2. Оюутны тоо.

Хуваарилалт		Оюутны тоо				
		Улсын сургууль	Хот аймгийн сургууль	Хувийн сургууль (А)	Нийт тоо (Б)	Хувийн сургуулийн хувь (А/Б)
Дээд боловсролын сургууль	Их, дээд сургууль	609,356	139,446	2,087,200	2,836,002	73.6
	2-3 жилийн их сургууль		9,004	144,327	153,331	94.1
	Ахлах сургуулийн 3 жилийг хасаад 2-3 жилийн их сургууль буюу 4, 5-р ангийн оюутан	19,532	1,477	765	21,774	3.5
	Нийт	628,888	149,927	2,232,292	3,011,107	74.1

http://www.mext.go.jp/a_menu/koutou/shiritsu/index.htm

Нэмж хэлэхэд: Улсын ба хот аймгийн их дээд сургуулийн элсэлтийн төлбөр 280,000 иэн, сургалтын төлбөр 1 жил ойролцоогоор 540,000 иэн.


Хувийн их дээд сургуулийн элсэлтийн төлбөр 300,000 иэн, сургалтын төлбөр хүмүүнлэгийн ухааны салбар - 1,000,000 иэн, Байгалийн ухааны салбар - 1,500,000 иэн.

2. Японы дээд боловсролын явц, онцлог

Дээд боловсролын өсөлтийн үе (1960-1973 он)-ийн дээд боловсролын үйл явц, онцлогийг өмнө өгүүлснээ энд дахин дурдъя.


Эдийн засгийн өндөр өсөлтөөс өмнөх үеийн Японы дээд боловсрол нь шинэчлэлийг хурдасгахын тулд, засгийн газар удирдсан эрчүүдэд төвлөрсөн зүйл байсан. Японы эдийн засгийн өсөлт нь жирийн иргэдийн боловсролд хандах шаардлагыг өндөржүүлж, дээд боловсролын хувийн байгууллагууд нэмэгдэхэд хүргэсэн. Гэхдээ, Японы улсын дээд боловсролын хөгжлийн гол шалтгаан нь энгийн ард түмэн дээд боловсрол эзэмших өөрсдийнхөн чин хүсэлт байсан.¹⁰

Японы дээд боловсролын огцом өсөлт нь олон иргэдэд дээд боловсрол эзэмших бололцоо олгож, үүний үр дүнд их, дээд сургуулиудын тоо ч нэмэгдсэн юм.




(Боловсролын Яам “Боловсролын статистик мэдээ”1977 оны байдлаар)
http://www.toukei.go.jp/b_menu/toukei/002/002b/1368900.htm

¹⁰ С.Туул МУИС, Шус, Хс, Гхст, багш (Ph.D), Монголын ба Японы дээд боловсролын зарим асуудал



http://www.mext.go.jp/b_menu/toukei/002/002b/1368900.htm



<http://nenji-toukei.com/n/kiji/10064/Их, дээд сургуульд элсэгчдийн харьцаанаас хийв>

Энэ хооронд (1954-1976 оны 22 жилийн хооронд) Японы эдийн засгийн цар хүрээ 5,8 дахин өсөж, 1969 онд дотоодын нийт бүтээгдэхүүнээрээ Европын орнуудыг ардаа орхиж дэлхийн хоёр дахь хөрөнгөтөн орон болсон юм.¹¹

¹¹ 高度成長から「経済大国」へ, p. 9

Өөрөөр хэлбэл, дараах байдлаар дүгнэж болно. (1) боловсролын нэр хүнд, (2) идэвхтэй өрсөлдөөн мөн (3) сургуулиудын хоорондын ялгааны зөрүүний өсөлт¹²

(3) Эрчимтэй өсөлт (1960-1973 он)-өөс, тогтвортой өсөлт (1973-1991 он), дараа нь бага хөгжлийн үе (1990 оноос хойш)

Япон улс "1973 оноос 1975 онуудад аж үйлдвэрлэл 20 орчим хувиар буурч, аж ахуйн нэгжүүдийн ашиг ойролцоогоор 6-1% хүртэл буурсан юм. Гэвч, энэхүү "дээд зэргийн зогсонги" байдлыг 1. Экспортыг нэмэгдүүлэх, 2. Мөнгө санхүүгийн зардлыг тэлэх, 3. "Хэмнэлттэй менежмент"-ийг идэвхтэй хэрэгжүүлснээр даван туулсан юм.¹³

Дээд боловсрол ч мөн адил, их, дээд сургуулиудын менежментэд өөрчлөлт оруулах шаардлагатай болсон юм. Өөрөөр хэлбэл, нэгдүгээрт, "Эрдмийн уурхай" гэгддэг байсан сургуулиуд, оюутнууд болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сургууль болж өөрчлөгдсөөр байна.

Хоёрдугаарт, эрдмийн зэрэг олгох сургуулийг өргөжүүлэн төрөлжүүлэх ажил хийгдэж байна.

Гуравдугаарт, насан туршдаа суралцахын тулд, дээд сургууль төгссөний дараах сургалтыг өргөжүүлэн, төрөлжүүлж, бэхжүүлж байна.

Дөрөвдүгээрт, их дээд сургуулийн менежментийг бэхжүүлж, чадваржуулж байна.

Өөрөөр хэлбэл, их сургуульд дэвшин суралцагсадын тоо нэмэгдэж байгаатай холбогдон их сургуулиуд нийгэмжсээр байна.¹⁴

(4.1) Улсын их сургууль, зарим хувийн их сургуулиуд дэлхийн их сургуулиудын даяаршлын өрсөлдөөнд оролцох шаардлагатай болж байна. Тиймээс, улсын их сургуулийн чанарыг сайжруулах шаардлагатай. Энэ нь, (Герман маягийн "Судалгаанд суурилсан ганцаарчилсан хэлбэр"-ээс Америк маягийн "Өрсөлдөөнд суурилсан аж үйлдвэржилт"-нд шилжиж байна.)

Амано Икүо энэ тухай ийнхүү дүгнэсэн байна.

1. Эдийн засгийн өсөлт буурч, дээд боловсролын салбарт олгодог мөнгөний хэмжээ багассан. (Жич: Засгийн газраас авах санхүүгийн нөөцийн багасалт)
2. Дээд боловсрол ба засгийн газар, компанийн нягт харилцаа нь оюун тусгаар тогтнолыг алдагдуулсаар байна. (Жич: Их сургуулийн бие даасан байдлын алдалт)
3. Дээд боловсролын тухайн засгийн газрын бодлого нь зах зээлийн өрсөлдөөний хандлагыг хүчтэй болгосон. (Жич: Их дээд сургуулиудын зах зээлийн эдийн засгийн өөрчлөлт)

¹² もういちど読む山川日本史, p. 330

¹³ 伊藤正直、高度成長から「経済大国」へ p. 46

¹⁴ 岩波書店、『変貌する高等教育』、「はじめに」

4. Судалгааны чиглэл нь онолын судалгаанаас хэрэглээний практик дадлага уруу шилждэг. (Жич: Энэ нь их дээд сургууль нь бусад компани байгууллагатай хамтарч ажиллах.)
5. Засгийн газар их дээд сургуулийг дэлхийд нээлттэй болгож, боловсролын хүрээг тэлдэг. (Жич: Их дээд сургуулийн боловсролын чанар, хүний нөөц гэх мэт зүйлсийн хэмжээг томсгох)
6. Дээд боловсрол олгодог их дээд сургуулиуд нь нэг талаас секторуудыг дотор нь маш нарийвчилдаг боловч нөгөө талаас бүгд ижил хэвээр байх ёстой гэсэн хандлага байна. (Жич: Их сургуулиуд нь өөр өөрийн онцлогтой болох буюу эсвэл дээд боловсрол нь бүгд ижил боловсрол өгч хэрэгтэй гэсэн 2 хандлага байна.)
7. Их сургуулиуд нь оюутнуудыг компанийн эзэн шиг бодох хандлага хүчтэй болж байна. (Жич: Их сургуулиуд өмнө нь зөвхөн оюутанд зааж сургаж байсан бол одоо оюутанд зааж сургасны дараа оюутан бүрээс ашиг авах компани болж байна)
8. Дээд боловсролын байгууллагын мөнгөний их үүсвэр нь оюутнуудаас авах сургалтын төлбөр дээр тулгуурлахаас гадна оюутан тэтгэлэг аваад, эргэж төлдөг тэр мөнгөн дээр тулгуурлаж байна. (Жич: Их, дээд сургуулиуд нь тусгаар тогтносон компани болж байна.)
9. Сургалтын хөтөлбөр нь ерөнхий математик, хэл шинжлэл, дэлхийн соёл иргэншлийн тухай хичээлүүдийг чухалчлан авч үздэг. (Жич: Үндэсний боловсрол ба дэлхийд нээлттэй боловсролыг чухалчилдаг.)
10. Сод авьяастай хүмүүс урилгаар өөр газар уруу явж, дүрвэх болсон. (Жич: хүний нөөцийн урсгал хүчтэй болдог)
11. Дээд боловсролын байгууллага хэвээр оршин тогтнож чадахгүй болж, өрсөлдөөн хүчтэй болдог. (Жич: Их, дээд сургуулиуд өрсөлдөөнд яаж ялах вэ гэдэг нь чухал болж байна.)
12. Гэвч их дээд сургуулиудын доторх хүмүүсийн хариуцлага багасаж, тус тусын тэмцээн хүчтэй болж байна. (Жич: Их, дээд сургуулиудын хоорондох тэмцээн хүчтэй болдог.)¹⁵

Өөрөөр хэлбэл дэлхийн даяаршлын өнөө үед Японы улсын улсын их дээд сургуулиуд ба хувийн том их дээд сургуулиуд хувьцаат компани шиг болж, гадаад дотоодын өрсөлдөөн хүчтэй болдог. Их дээд сургуулиуд нь капитализмын хүчтэй өрсөлдөөнд ордог. (4.2) Японд нөгөө талаас дунд ба бага хувийн их, дээд сургуулиудыг ч гэсэн өөрчлөх хэрэгтэй болж, оюутны тоо нь их дээд сургуулиудын тогтмол тоонд хүрэхгүй, их дээд сургуулиуд бий болдог.

¹⁵ 天野郁夫、「高等教育の大衆化と構造変動」pp. 25-26, 『変貌する高等教育』所収

Угава Хироши гуай тийм их дээд сургуулиудыг “Гинкай Даяаг буюу Хил их дээд сургууль” гэж нэрлэж байна.

Угава Хироши хэлэхдээ Оюутны тоо нь хэмжээндээ хүрэхгүй их, дээд сургуулиудын тоо 1999 онд 89 байсан нь 2001 онд 149 болсон. 2008 онд 266 болж, бараг хоёрны нэг хувь буюу хагас хувь нь орон тоондоо хүрэхгүй болсон. Ойрын ирээдүйд эдгээр их, дээд сургуулиудыг хаах аюул учирч байна.¹⁶

Тийм “Гинкай Даяаг буюу Хил их дээд сургууль” яаж тийм нөхцөлөөс гарах вэ? 2012 оны 6 сард Боловсрол ба Шинжлэх Ухааны Яам “Их, Дээд сургуулиудын өөрчлөлт хэрэгжүүлэх хөтөлбөр” гаргасан. Уг хөтөлбөрт Их, дээд сургуулиудын “COC буюу Center of Community” хөтөлбөр багтаж байна. COC хөтөлбөрт: Тухайн газрын асуудлыг шийдвэрлэхэд туслах, судалгааны ажлыг чухалчилж байна гэж бичдэг. Тийм бага, дунд их, дээд сургуулиуд тухайн газар бүс нутгийн хэрэгцээнд тохирсон хариулт өгөх, боловсрол ба судалгааг тууштай хийж, боловсрол, судалгааны чанарыг дээшлүүлсээр тусгай газар дахь байр суурийг дээшлүүлж хэрэгтэй байна.¹⁷

Өөрөөр хэлбэл бага, дунд их, дээд сургуулиудын дампуурлын аюулаас аврах, тухайн газартай нягт холбоо байгуулах, их, дээд сургуулиудыг туршиж байна.

Дүгнэлт

Япон улсын Засгийн газрын бодлогын нэг чухал чиглэл нь дээд боловсрол асуудал буюу эдийн засгийн өсөлтөд чиглэсэн боловсролын бодлогыг төрийн санаачилгаар дэмжиж иржээ. Үүний үр дүнд эдийн засгийн өсөлтөд дээд боловсрол гол үүрэг гүйцэтгэсэн байна. Гэвч дээд боловсрол нь голлон эрчүүдэд төвлөрч эдийн засаг өсөхийн хэрээр эмэгтэйчүүдийг албадан гэрт нь байлгах нь зонхилж байв.

Иймд, Японы дээд боловсролын систем нь голдуу нэг талаас Засгийн газарт хүний нөөц бий болгох буюу удирдагч бэлдэх их, дээд сургууль, нөгөө талаас бизнесийн нийгэм буюу бизнесийн нийгэмд хүний нөөц бэлтгэх мэргэжлийн сургууль бий болгох хосолмол бүтэц байсан юм.

Дэлхийн II дайны дараа Японы боловсролын систем нь ардчилсан боловсролын шинэчлэлийн үндсэн дээр тулгуурлан 1950 оноос хурдацтай хөгжих болж, 1960-аад онд дээд боловсролын байгууллагуудын тоо эрс нэмэгдсэн байна. Энэ хугацаанд дөрвөн жилийн сургалттай 138 их, дээд сургууль, 199 коллеж шинээр нэмэгджээ.

1970-аад онд Япон улс эдийн засгийн супер гүрэн болж, энэ үед ард

¹⁶ 小川洋. 消えゆく「限界大学」(Kindleの位置No. 335-341). 白水社. Kindle版.

¹⁷ 小川洋. 消えゆく「限界大学」(Kindleの位置No. 1423-1428). 白水社. Kindle版.

түмэн дээд боловсрол эзэмшихийг нийтээр хүсэх болов. Гэсэн хэдий ч төрийн хяналтад байдаг дээд боловсролын байгууллагуудын тоо хязгаарлагдмал байсан бөгөөд хүн амын олонх нь хувийн зардлаар хувийн их, дээд сургуульд элсдэг байв. Өөрөөр хэлбэл, дээд боловсрол улам бүр түгээмэл болсон ч боловсролд зарцуулах зардлын, хувь хүний ачаалал их болсон байна.

Гэсэн хэдий ч 1990-ээд онд Япон улс эдийн засгийн өсөлт нь бага өсөлтийн үе уруу шилжсэн. Үүнтэй зэрэгцэн Японы дээд боловсрол нь олон улсын стандарт чанартай нийцэхүйц, боловсронгуй байхыг шаардах болсон. Түүнчлэн их, дээд сургуульд элсэгчдийн тоо буурч, ялангуяа хувийн их, дээд сургуулиудад энэ бууралт илүүтэй ажиглагдах болжээ.

Үүнээс үүдэн их, дээд сургуулиудын тоо цөөрч, өөрсдөө оршин тогтнохын тулд арга хэмжээ авах, тухай асуудал үүссэн. Үүний нэг арга хэмжээ нь бүс нутаг бүрд тохирсон боловсролыг дэмжих, (их, дээд боловсролыг нутагшуулах) шаардлага тавигдсан байна.

Япон улсын дээд боловсролын хөгжлийн үндсэн шалтгаан нь энгийн ард түмэн дээд боловсрол эзэмших чин хүсэлт байсанд оршино.

Тиймээс Япон орны боловсролын хөгжлийн туршлагаас судлахын тулд бид бүхэн нэгдүгээрт, улс орныхоо нийгэм эдийн засгийн хөгжлийг дээшлүүлэх, хоёрдугаарт, Засгийн газраас дээд боловсролын системд анхаарал хандуулах, гуравдугаарт, хувь хүний ёс суртахууны ухамсрыг дээд түвшинд хүргэх (дээд боловсрол эзэмших чин сэтгэлтэй байх, диплом авахын тулд сурах биш) нь чухал байна гэж үзэж байна.

Ашигласан ном, хэвлэл

1. С.Туул. 1990 оноос хойших Монгол Болгар улсын Дээд боловсролын хөгжлийн чиг хандлагууд. Софи
2. З. Мөнхдалай, Дээд боловсролын загварууд 1999, 2000
3. Дээд боловсролын сургалтын байгууллагыг аттестатчилах журам, 2011 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 3214 дугаарт бүртгэгдсэн. Монгол Улсын Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын тушаал, 2011 оны 01 сарын 13 өдөр. Монгол Улсын хууль, Дээд боловсролын тухай, 2002 оны 05 дугаар сарын 03-ны өдөр.
4. OECD, *Education of a Glance 2015: OECD Indicator*, OECD Publishing
5. Higher Education Bureau, Ministry of Education, Culture, Sports, Science and Technology, *Higher Education in Japan*,

6. http://www.mext.go.jp/english/highered/_icsFiles/afiedfile/2012/06/19/1302653_1.pdf
7. Ruth Benedict, *The Chrysanthemum and the Sword: Patterns of Japanese Culture*, 1946
8. Бүшидо: Япон үндэстний ёс зүйн цогц р. р.83 япон хэлнээс орчуулсан Дэлэгийн Төмөрбаатар
9. Миякэ Эрико, Эрэгтэй, эмэгтэйчүүдийн хамтын оролцоотой нийгэм дэх охидын ахлах сургуулийн боловсролын өнөөгийн асуудал - Doshisha эмэгтэйчүүдийн коллежийн замналын жишээн дээр, өнөөгийн нийгэм хэлэлцүүлэг No. 9, 16-38, 2013
10. Оомори Тооа "19-р зууны Америк, Европын дээд боловсролын загвар ба Японы загвар бүрэлдсэн нь – Ивамүрагийн дипломат багийн америк, европын дээд боловсролын тархац"
11. Сайто Ясүо "Японы боловсролын хөгжлийн түүх"
12. Иномата Тошиюүки "Японы дээд боловсролд хамааралтай бодлогын өрнөлт - Дээд боловсролтой холбоотой орон нутгийн байршилтай холбоотой бодлого"